



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Зөвлөлдөх санал асуулгын 2 дугаар шатны үйл ажиллагааны бэлтгэл хангах Дэд ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг зэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 4, 5 дугаар зүйл, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 7 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/107 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зөвлөлдөх санал асуулгын 2 дугаар шатны үйл ажиллагааг 2023 оны 02 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд зохион байгуулах болсонтой холбогдуулан дүүргээс оролцох иргэдийн оролцоог хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Дэд ажлын хэсгийг байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Санал асуулгад оролцох оролцогчдод ажлын өдрүүдэд чөлөө олгуулах, иргэдийн идэвх оролцоог хангах, олон нийтэд сурталчлах, иргэдийн хувийн бэлтгэлийг хангуулах, унаагаар ирүүлж, буцаах арга хэмжээ авч, Зөвлөлдөх санал асуулгын 2 дугаар шатны үйл ажиллагаанд оролцогчдын бэлтгэлийг ханган оролцуулахыг Дэд ажлын хэсэг (Д.Эрдэнэтуяа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 04 сарын 07-ны өдрийн 430 дугаар
захирамжийн хавсралт



ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Д. Эрдэнэтуяа	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	Ш. Баасансүрэн	Боловсролын хэлтсийн дарга
	Х. Ганбат	Эрүүл мэндийн төвийн дарга
	Б. Цогбадрах	Онцгой байдлын хэлтсийн дарга
	Т. Лхагвасүрэн	Цагдаагийн хэлтсийн дарга
	Н. Нямзав	1 дүгээр хорооны Засаг дарга
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Ж. Наранцэцэг	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Оюунтөгс	Дүүргийн Статистикч